


## Хэрэглэгчийн ИТГЭЛИЙН ИНДЕКС



Дэлгэрэнгүй хувилбарыг  
[www.forum.mn](http://www.forum.mn)  
портал сайтаас үзнэ үү.

### ОРШИЛ

Сүүлийн 6 сарын хугацаанд эдийн засагт хэрэгжүүлсэн бодлого, тухайлбал, макро эдийн засгийн мөнгө, сангийн хатуу бодлого суларсан нь Улаанбаатар хотын өрхүүдийн ажил эрхлэлт, амьжиргаанд нааштай нөлөөлсөн байна. Гэхдээ хэрэглэгчдийн үзэж байгаагаар эдийн засаг уналтын байдалтай хэвээр байгаа бөгөөд харин хагас жилийн дараа байдал хэвийн болох хүлээлт байна.

Дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө 2008 оны сүүлчээс эхлэн Монголын эдийн засагт мэдрэгдэж эхэлсэн бөгөөд хямралын үр дагавар одоо ч үргэлжилсээр байна. Энэ нөхцөлд эдийн засгийн өнөөгийн байдал болон цаашдын хандлагын талаарх судалгаа шинжилгээ, ялангуяа, Монголчууд эдийн засгийн байдлыг хэрхэн үнэлж буй болон ойрын ирээдүйд ямар хүлээлттэй байгаа талаарх мэдээ мэдээлэл туйлын ач холбогдолтой билээ. Иймээс Монголын өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж буй болон аль хэр өөдрөг хүлээлттэй байгааг тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийх, олон нийтэд энэ талын мэдээлэл хүргэх зорилготойгоор хэрэглэгчийн итгэлийн индекс түүвэр судалгааг анх 2009 оны дөрөвдүгээр сард хийсэн бол зургаан сарын дараа хоёрдахь судалгааг хийлээ.

Эдийн засгийн нийт эрэлтийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг нь хувийн хэрэглээний зардал байдаг. Монгол Улсад ч бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн хамгийн том худалдан авагч нь монголын нийт өрх бөгөөд ҮСХ-ны мэдээлснээр 2008 онд өрхийн хэрэглээ ДНБ-ий 52 хувийг эзэлж байна. Хувь хүн, айл өрхүүд хэрэглээний зардал, хадгаламжаа төлөвлөхдөө орлого, ажил эрхлэлт, үнийн түвшин, хүү, банк санхүүгийн тогтвортой байдал зэрэг үзүүлэлтийн өнөөгийн байдал, ирээдүйн өөрчлөлтийн талаар өөрсдийн таамаглал, хүлээлтэд үндэслэн шийдвэрээ гаргадаг. Жишээлбэл, орон сууц худалдаж авах эсэх тухай шийдвэр гаргахад орон



сууцны ирээдүйн үнийн талаарх таамаглал өнөөгийн үнийн нэг адил чухал нөлөөтэй. Өөр бусад хүчин зүйлс тогтмол үед, өрхүүд цаашдаа үнэ буурна гэж таамаглаж байвал орон сууц худалдаж авахаа хойшлуулах ба харин үнэ өснө гэж таамаглаж байвал худалдаж авах шийдвэр гаргана. Өрхийн энэхүү шийдвэр нь орон сууцны барилгын салбарын үйлдвэрлэгчдэд шууд нөлөөтэй юм. Эндээс үзвэл, Монголчууд ойрын ирээдүйд эдийн засаг хэрхэн өөрчлөгдөнө гэж хүлээж буйгаас манай бизнес, санхүүгийн байгууллагынхны үйл ажиллагаа шууд хамаарна. Тухайлбал, Монголын өрхүүд эдийн засгийн байдал тааруухан байна гэсэн хүлээлттэй байвал өрхийн зарлагаа бууруулахаар төлөвлөх ба өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт буурах тухай энэхүү мэдээлэл нь пүүс, компаниудын хувьд үйлдвэрлэлээ өсгөхгүй байх, хөрөнгө оруулалтаа хойшлуулах болон нөөцөнд байгаа бүтээгдэхүүний борлуулалтад илүү анхаарах зэрэг шийдвэр гаргахад хүргэнэ. Иймд гадаад орнуудад төрийн болон хувийн бизнес санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийн хүлээлтийн индексийг маш анхааралтай ажиглаж, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулж тооцдог байна. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь эдийн засгийн өнөөгийн байдал, ойрын ирээдүйн өөрчлөлтийн төлвийг өрхүүд хэрхэн үнэлж (таамаглаж) байгааг харуулдаг бөгөөд түүнтэй төстэй индексүүдийг олон улс оронд тооцож гаргадаг. Энэ судалгаагаар Монгол улсын “Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийг Улаанбаатар хотын бүх өрхийг хамарсан санамсаргүй түүвэр судалгааны аргаар хоёрдахь удаагаа тооцоолсон нь цаашид тогтмол хэрэглэх боломжийг нээж өгч байгаагаараа ач холбогдолтой юм. Ялангуяа, ойрын ирээдүйд бүтээгдэхүүн

үйлчилгээний эрэлт хэрхэн өөрчлөгдөх талаарх мэдээлэл нь эдийн засгийн эгзэгтэй энэ үед төрийн болон хувийн байгууллагуудад бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөхөд нэн чухал байх болно.

Манай оронд үүнтэй төстэй индексийг МҮХАҮТ жил бүр бизнес эрхлэгчдийн дунд явуулдаг түүвэр судалгаагаар тооцож гаргасан байна. Харин бидний энэ судалгаа нь, нэгдүгээрт, Улаанбаатар хотын нийт өрхийг хамруулан санамсаргүй түүвэрлэлт хийснээр судалгааны үр дүн нь Улаанбаатар хотын нийт өрхийг (хэрэглэгчдийг) төлөөлж чадахаараа онцлогтой. Хоёрдугаарт, уг түүвэр судалгааг жилд 2 удаа 6 сарын интервалтай явуулснаар эдийн засгийн төлөв байдал асар хурдан өөрчлөгдөж буй энэ үед хэрэглэгчийн итгэл хагас жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдээлэл өгөх боломжтой юм.

### ХИИ-ийн судалгаа, тооцох аргачлал

Хэрэглэгчийн Итгэлийн Индексийг тооцох түүвэр судалгааг Улаанбаатар хотод хоёр шатлалаар хийхээс эхний шатанд хороодыг хүн амынх нь тоотой пропорционалиар санамсаргүйгээр сонгосон ба дараагийн шатанд сонгогдсон хороодоос өрхүүдийг мөн л санамсаргүйгээр сонгосон болно. 2007 оны 12-р сарын 31-ний байдлаар Улаанбаатар хотын албан ёсны байнгын оршин суугчдын тоо 1005093, нийт өрхийн тоо 234923 байна. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, 132 хорооноос бүрддэг. Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хүн амын төвлөрөл харьцангуй өндөр, харин захын дүүргүүд болох Налайх, Багануур, Багахангайд хүн амын төвлөрөл эрс бага буюу нийт өрхийн дөнгөж 6 хувийг эзэлж байна.

### Түүврийн хэмжээ

Хэрэглэгчийн Итгэлийн Индекс үнэлэх түүвэр судалгааны түүврийн оновчтой хэмжээг дараахь томъёогоор тодорхойлсон.

$$n = \left[ \frac{z_{\alpha/2}^2 p(1-p)}{e^2} \right]$$

Энд: n-түүврийн хэмжээ,

p- тухайн сонголт хийх хүн амын хувь,

e- итгэх завсар,

$\alpha$ - ач холбогдлын түвшин,

z- критик утга.

Түүврийн хэмжээг тодорхойлох параметрууд болох ач холбогдлын зэрэг 5%, итгэх завсар 3.1% байхаар авч байна. Харин p-ийн талаар урьдчилан таамаглах боломжгүй тул 0.5 буюу түүврийн хэмжээ хамгийн их байлгах утгыг нь сонгосон. Тооцооноос үзвэл түүврийн оновчтой хэмжээ нь 999 өрх байна.


### Хоёр шатлалт санамсаргүй түүвэр

Түүвэр судалгааны эхний шатанд Улаанбаатар хотын 120 хорооноос өрхийн тоотой нь пропорционал магадлалтайгаар 40 хороог санамсаргүйгээр сонгож харин хоёрдугаар шатанд сонгогдсон хороо тус бүрээс 25 өрх санамсаргүйгээр сонгож,<sup>1</sup> сонгосон өрхүүдээс асуулга авах замаар мэдээлэл цуглууллаа.

### Түүвэр судалгааны аргачлал, асуулга

Хэрэглэгчийн итгэлийн индексийг тооцохдоо улс орнууд хагас жил, жил, 5 жил хүртэлх хугацааг хамруулсан байдаг. Энэ удаагийн асуулгад бид нэгээс дээш жилийн хугацааг хамруулаагүй.

<sup>1</sup> Багануур, Багахангай, Налайх дүүргийн 12 хороог түүвэрлэлтэд хамруулаагүй. Эдгээр дүүргүүд нийлээд УБ хотын нийт өрхийн 6 хувийг эзэлдэг бөгөөд байршлын хувьд хотоос нэлээд алслагдсан байдаг.



Улаанбаатар хотын “Хэрэглэгчийн Итгэлийн Индекс” тодорхойлох судалгааны асуулга нь:

- өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн дүгнэж буй байдал
- эдийн засгийн ойрын төлвийг хэрхэн үнэлж (таамаглаж) буй байдал
- ойрын ирээдүйн хэрэглээг хэрхэн төлөвлөж буй байдал зэрэг хүрээг хамарсан юм.

Түүвэр судалгааны асуулга нь эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх өрхийн үнэлгээ, ирээдүйн өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт, ойрын ирээдүйн худалдан авалтын хандлага, 6 болон 12 сарын хугацаанд эдийн засгийн зарим үзүүлэлтэд гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт болон өрхийн тухай мэдээлэл гэсэн үндсэн 5 хэсгээс бүрдэж байна. Одоо эдгээр бүлэг асуултуудыг тус бүрд нь авч үзье.

#### A. Эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх өрхийн үнэлгээ

Энэ хэсгийн зорилго нь Монголчууд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг гаргах бөгөөд уг хэсэг нь ажил эрхлэлт, бизнесийн нөхцөл, удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлтийн өнөөгийн байдалд өрхийн өгч буй үнэлгээ болон өрхийн санхүүгийн байдалд нэг жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийн талаарх нийт 4 асуултаас бүрдэнэ.

#### B. Ирээдүйд эдийн засагт гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт

Энэ хэсэг нь Монголчууд бизнесийн нөхцөл, ажил эрхлэлт, орлогод ирэх 6 сарын хугацаанд гарах өөрчлөлтийн талаар ямар хүлээлтэй байгааг үнэлэх зорилготой 3 дэд асуултаас бүрдэнэ.



А, В хэсгийн асуултууд, хариултын сонголтыг олон улсад хийгддэг хэрэглэгчийн итгэлийн (хүлээлтийн) талаарх түүвэр судалгаануудад өргөн хэрэглэгддэг стандарт асуултуудаас сонгон авсан<sup>2</sup>. Тухайлбал, АНУ, Англи, Австрали, Япон, Украин, Хятад, Өмнөд Солонгос, Канад зэрэг олон улсад эдгээр асуултыг хэрэглэн индексээ тооцдог.<sup>3</sup> А хэсгийн эхний 2 асуулт болон В хэсгийн 3 асуултын мэдээлэл нийлээд ХИИ тооцоход ашиглагдана.

#### *С. Ойрын ирээдүйн худалдан авалтын хандлага*

Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдан авалт болон аялал жуулчлал нь эрэлтийн мэдрэмж өндөртэй байдаг. Эдийн засгийн мөчлөгийн талаарх тогтсон баримтаас үзвэл эдгээр бүтээгдэхүүний хэрэглээний зардал нь эдийн засгийн мөчлөгийн дагуу өөрчлөгддөг ба өөрчлөлтийн хэмжээ нь ДНБ-ий өөрчлөлтөөс хэд дахин их буюу далайц ихтэй байдаг.<sup>4</sup> Жишээлбэл, эдийн засгийн уналтын үед өрхүүд юуны өмнө автомашин, цахилгаан бараа зэрэг удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний хэрэглээний зардлыг бууруулдаг.

Энэ хэсэгт бид өрхүүдээс ирэх 6 сарын хугацаанд орон сууц, гэр, газар зэрэг үл хөдлөх хөрөнгө, автомашин, цахилгаан бараа болон аялал жуулчлалын үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж буй эсэх талаар мэдээлэл авсан юм. Ингэснээр ойрын ирээдүйд Монголд удаан

эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлт ямар байх талаар мэдээлэлтэй болж дараа дараагийн үр дүнг харьцуулах суурь бий болно. Иймээс хоёрдахь удаагийн судалгаанаас эхлэн энэхүү эрэлтэд гарсан өөрчлөлтийг үнэлэх боломж бүрдэж байна.

#### *Д. Эдийн засгийн гол гол үнийн түвшин ирэх 6 болон 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх тухай өрхүүдийн хүлээлт*

Дээр дурдсанчлан өрхүүдийн хэрэглээ, хадгаламжийн талаарх шийдвэрт өнөөгийн үнийн түвшин төдийгүй, үнийн түвшин ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх таамаглал нэн чухал байдаг. Ирэх хагас болон бүтэн жилийн хугацаанд инфляци, зээлийн хүү, төгрөгийн ханш, орон сууцны үнэ хэрхэн өөрчлөгдөх талаарх таамаглалыг үнэлж хүлээгдэж буй инфляци, төгрөгийн ханшийг тооцох боломжтой болно. Олон улсад хийгдэж байгаа ижил төстэй судалгаанаас үзэхэд эдгээр үзүүлэлт 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх талаар асуудаг, харин манай орны хувьд эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн хурдтай өөрчлөгдөж байгаа учир асуулгад 6 сарын хугацааг оруулсан.

#### *Е. Өрхийн тухай мэдээлэл*

Өрхийн тэргүүний нас, өрхийн ам бүл, боловсрол зэрэг мэдээлэл нь түүвэр судалгааг эх олонлогтой харьцуулж, түүнийг хэр зэрэг төлөөлж байгааг шалгах ач холбогдолтой. Түүнчлэн түүврийн тархалтад тодорхой хэмжээний гажилт байвал аль чиглэлд байгааг тодорхойлж, судалгааны үр дүнгийн шинжилгээнд оруулж тооцно. Өрхийн орлого, үл хөдлөх хөрөнгө, ажил эрхлэлтийн байдал зэрэг үзүүлэлтэд үндэслэн Улаанбаатар хотын хэмжээнд орлого хуваарилалт, ядуурлын

2 Өрхийн хэрэглээний шийдвэрт өрхийн байнгын буюу насан туршийн орлого нөлөөлдөг. Хэрвээ өрхийн байнгын орлого өсвөл тэд хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой, харин түр зуурын орлогын өсөлт нь хэрэглээнд төдийлөн нөлөөлөхгүй гэж үздэг. Байнгын орлого нь өнөөгийн болон ирээдүйн орлогоор тодорхойлогддог учраас энэ төрлийн судалгаануудад өнөөгийн болон ирээдүйн орлоготой холбоотой асуулгуудыг оруулдаг.

3 Conference Board, Michigan, Washington-ABC News Consumer Comfort Index MasterCard Worldwide index of consumer confidence

4 Mankiw, N.Gregory, 1982 "Hall's consumption hypothesis and durable goods", Journal of Monetary Economics 10, 417-425



түвшин, ажил эрхлэлтийн байдлыг үнэлэхээс гадна үзүүлэлтүүдтэй холбоотой судалгааны үр дүнг бусад судалгаатай харьцуулах боломж олгох юм. Түүнчлэн, өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг Улаанбаатар хотын нийт өрхийг төлөөлөх түүвэр судалгаанаас үнэлэн гаргах нь бодлого боловсруулагчдад ихээхэн ач холбогдолтой юм. Ажил эрхлэлтийн талаарх асуултууд нь Үндэсний статистикийн хорооны ажил эрхлэлтийн байдал, ажилгүйдлийн шалтгааныг тодорхойлдог аргачлалд үндэслэсэн. Ажилгүйдлийн байдлыг тодорхойлох асуудлуудтай холбоотойгоор ҮСХ, НХХЯ-ны зарим мэргэжилтэнтэй зөвлөлдсөн болно.

Энэ удаагийн түүвэр судалгаа нь дээр дурдсан үзүүлэлтүүдийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж, дээрх үзүүлэлтэд сүүлийн 6 сард гарсан өөрчлөлтийн хандлагыг шинжлэх, боломжтойгоороо онцлог болно.

## Түүвэр судалгааны үр дүн

### Түүврийн алдаа

Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) судалгааны түүврийн төлөөллийг шинжлэхдээ “Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого: Улаанбаатар хотын тооллогын дүн”, “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008” түүвэр судалгаа зэрэг бусад судалгаатай өрхийн ам бүл, орон сууцны нөхцөл болон өрхийн тэргүүний талаарх зарим мэдээллийг харьцуулж үзсэн болно.

Гэр хороололд амьдарч байгаа өрхүүд нь ХИИ-ийн эхний болон хоёрдахь түүвэр судалгааны хувьд харгалзан нийт өрхийн 61.2 ба 64.2 хувь байна. ХИИ-1 түүвэр судалгааны тус үзүүлэлт

нь ӨНЭЗС-ны үр дүнтэй (59.7 хувь) ойрхон байна. Харин гэр хороололд гэрт амьдардаг өрхийн тоо харьцангуй бага, хашаа байшинд амьдардаг өрхийн хувь өндөр байна. Орон сууцанд амьдарч буй өрх 34.2 хувь байгаа нь өмнөх ХИИ түүвэр судалгаатай ойрхон боловч хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс 10 пункт, ӨНЭЗС-ны дүнгээс 5 пунктээр бага байна. Өмнөх ХИИ түүвэр судалгааны үр дүнтэй адил, орон сууцанд амьдардаг өрхийн хувь бага байгаа нь Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор гэр хороолол илүү ихээр тэлж байгааг харуулж байж болох юм.

### Хүснэгт 1. Орон сууцны төрөл

	ХИИ-1 (Улаанбаатар)	ХИИ-2 (Улаанбаатар)	Хүн ам, орон сууцны тооллого (Улаанбаатар, 2000)	ӨНЭЗС 2007-2008 (Хот)
Гэр	21.9	15.6	21.8	28.8
Хашаа байшин	39.7	48.6	30	30.9
Орон сууц	35.4	34.2	44.8	39.8
Бусад	3	1.6	3.4	0.5
Нийт	100.0	100.0	100.0	100.0

2008 оны байдлаар улсын хэмжээнд өрхийн дундаж ам бүл 4.0 байсан бол ХИИ-1 түүвэр судалгааны үзүүлэлт 4.05, ХИИ-2 судалгааны өрхийн дундаж ам бүлийн тоо 4.13 байна. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор дундаж ам бүлийн тоо 4.7 байсан бол жилээс жилд буурсаар байна. ӨНЭЗС-ны өрхийн дундаж ам бүлийн тоо хамгийн бага 3.9 гарсан байна.

## Хүснэгт 2. Өрхийн ам бүлийн тоо

	ХИИ-1 (Улаанбаатар)	ХИИ-2 (Улаанбаатар)	Хүн ам, орон сууцны тооллого (Улаанбаатар, 2000)	ӨНЭЭС 2007-2008 (Хот)	2007 оны статистик-ийн эмхтгэл	2008 оны статисти-кийн эмхтгэл
Өрхийн ам бүлийн тоо	4.05	4.13	4.7	3.9	4.1	4.0

Гэр хороололд амьдарч байгаа өрхүүдийн өрхийн дундаж ам бүлийн тоо орон сууцны өрхүүдтэй харьцуулахад өндөр байгаа нь ХИИ түүвэр судалгаанууд болон ӨНЭЭС-ны үр дүнгүүдээс харагдаж байна. Орон сууцанд амьдарч байгаа өрхүүдийн дундаж ам бүлийн тоо нь ХИИ түүвэр судалгаануудад маш ойролцоо 3.8 байхад ӨНЭЭС-ных 3.5 байжээ. Ерөнхийдөө ӨНЭЭС-ны дундаж ам бүлийн тоо бусад судалгааны үр дүнтэй харьцуулахад бага байлаа (Хүснэгт 2 ба 3).

## Хүснэгт 3. Өрхийн дундаж ам бүлийн тоо, орон сууцны төрлөөр

	ХИИ-1 (Улаанбаатар)	ХИИ-2 (Улаанбаатар)	ӨНЭЭС 2007-2008 (Хот)
Гэр	4.23	4.33	4
Хашаа байшин	4.2	4.3	4.2
Орон сууц	3.8	3.78	3.5
Бусад	3.97	4.06	3.4

Өрхийн дундаж ам бүлийг дүүргээр харахад Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүд ХИИ-ийн хоёрдахь түүвэр судалгаанд аль алинд нь дундаж үзүүлэлтээс өндөр гарсан байна. Харин ХИИ-ийн хоёрдахь түүвэр судалгаанд Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдэд дундаж ам бүлийн тоо дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотын гэрт амьдардаг нийт өрхүүдийн гуравны нэг орчим нь Сонгинохайрхан

дүүрэгт харьяалагдаж байхад Баянгол дүүрэгт хамгийн бага буюу 10 хувь нь амьдардаг байна.

## Хүснэгт 4. Өрхийн дундаж ам бүл, дүүргээр

	Нэг өрхөд ногдох хүний тоо		Орон сууцны төрөл, гэрт		Нийт гэрт амьдардгаас		Нийт байшинд амьдардгаас	
	ХИИ-1	ХИИ-2	ХИИ-1	ХИИ-2	ХИИ-1	ХИИ-2	ХИИ-1	ХИИ-2
Хан уул	4.56	4.33	44	24	15.1	11.5	5.4	6.8
Баянзүрх	3.84	4.28	26.3	14.7	21	21.2	16.5	22.7
Баянгол	3.93	3.74	12	10.7	8.2	10.3	16.9	15.9
Сүхбаатар	3.98	3.90	13.6	11.3	15.5	10.9	27.7	15.8
Чингэлтэй	3.87	4.34	16	12.6	11	14.1	16.1	18.1
Сонгинохайрхан	4.37	4.14	32	22.2	29.2	32.1	17.4	20.7
Нийт					100	100	100	100

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Өрхийн тэргүүний насны бүлгээр өрхүүдийн эзлэх хувийг Хүснэгт 5-д харууллаа. Өрхийн тэргүүний насны бүлгүүд ойролцоо байгаа боловч ХИИ-2 түүвэр судалгааны насны бүлгийн тархалт ӨНЭЭС-ны үзүүлэлттэй адилхан байна.

## Хүснэгт 5. Өрхийн тэргүүний насны бүлэг, хувиар

	ХИИ-1 (Улаанбаатар)	ХИИ-2 (Улаанбаатар)	ӨНЭЭС 2007-2008 (Хот)
<30	12	11.3	11
30-39	23.6	28.1	28
40-49	32.9	30.3	31.3
50-59	19	17.9	16.4
60=<	12.5	12.4	13.4

Улаанбаатар хотын нийт өрхийн гуравны нэг орчим нь 40-50 насны тэргүүнтэй өрхүүд байна. "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008"-д өрхийн тэргүүний дундаж нас



Улаанбаатар хотод 45.9 байсан бол ХИИ түүвэр судалгаануудын дүнгээр энэ нь харгалзан 44.6 болон 44 байна (Хүснэгт 6).

2007-2008 оны ӨНЭЗС-ны дүнгээр эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрх нь улсын хэмжээнд нийт өрхийн 78.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 71.7 хувийг эзэлж байжээ. Харин ХИИ түүвэр судалгаануудад хамрагдсан нийт өрхийн харгалзан 79.6 болон 85.3 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй байжээ. ХИИ-2 түүвэр судалгаанд эмэгтэй тэргүүнтэй өрхийн хувь бага байсан.

#### Хүснэгт 6. Өрхийн тэргүүний дундаж нас, хүйс

	ХИИ-1 (Улаан- баатар)	ХИИ-2 (Улаан- баатар)	ӨНЭЗС 2007- 2008 (Улаан- баатар)
Өрхийн тэргүүний дундаж нас	44.55	44	45.9
Эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн хувь	79.6	85.3	71.7

Жич: ӨНЭЗС-гаар 2002-2003 онд эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн хувь 76.6 байсан.

ХИИ түүвэр судалгааны дүнгээр Улаанбаатар хотод өрхийн тэргүүний боловсролын түвшин улсын дундажтай харьцуулахад нэлээд өндөр байна (Хүснэгт 7).

#### Хүснэгт 7. Өрхийн тэргүүний боловсролын түвшин

	ХИИ-1 (Улаан- баатар)	ХИИ-2 (Улаан- баатар)	ӨНЭЗС 2007- 2008 (Улсын дундаж)
Бага	2.8	1.9	15.8
Бүрэн бус дунд	9.9	10.2	23.1
Бүрэн дунд	32.6	38.2	31.4
Тусгай мэргэжлийн сургууль	11.8	12.6	13
Дээд, магистр	42.9	37.1	16.6

ХИИ түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн шинж байдал, үндсэн үзүүлэлтүүд нь “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2007-2008” болон “Хүн ам, орон сууцны тооллого 2000” судалгааны үр дүнтэй маш ойрхон бөгөөд бидний түүврийн үр дүн 96.9 хувийн найдвартай байгаа учраас ХИИ түүвэр судалгаа нь Улаанбаатар хотын өрхүүдийг төлөөлөх чадвартай гэж үзэж болно. Иймээс бидний судалгааны үр дүн нь судалгаанд хамрагдсан өрхүүдээр хязгаарлагдахгүйгээр Улаанбаатар хотын нийт өрхүүдийн хувьд яригдаж байна гэсэн үг юм.

#### Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)

ХИИ нь 0-ээс 200-ын хооронд утга авах ба 100-аас их бол итгэл сайн, бага бол итгэл муу байна гэсэн үг. Энэ удаагийн судалгааны үр дүнг өмнөх судалгаатай харьцуулан, хэрэглэгчийн итгэл энэ хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг харах боломжтой юм. 2009 оны 4 болон 11 сард хийгдсэн түүвэр судалгаанаас тооцсон ХИИ-ийг Хүснэгт 8-д харуулж байна.

#### Хүснэгт 8. Хэрэглэгчийн Итгэлийн Индекс

	ХИИ	
	2009.04	2009.11
Хэрэглэгчийн Итгэлийн Индекс	36.7	82.8
Өнөөгийн байдлын индекс	12.9	40.3
Хүлээлтийн индекс	52.6	111.1

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

2009 оны 4 сарын байдлаар Улаанбаатар хотын ХИИ 36.7 буюу хэрэглэгчдийн итгэл тааруухан байсан бол 11 сарын судалгаагаар ХИИ 82.8 болсон нь хэрэглэгчдийн итгэл хагас жилийн өмнөхөөс нэлээд дээшилсэн болохыг



харуулж байна. 2009 оны 4 сарын байдлаар өрхүүд тухайн үеийн эдийн засгийн байдлыг маш муу гэж үнэлж байсан бол хагас жилийн дараа байдал тухайн үеийнхээс арай дээрдсэн боловч муу хэвээр байна гэжээ. Түүнээс 6 сарын дараа буюу 11 сард явагдсан ХИИ-ийн хоёрдахь түүвэр судалгаагаар Улаанбаатар хотын хэрэглэгчид өнөөгийн эдийн засгийн байдлыг муу (өнөөгийн байдлын индекс 40.3) гэж үнэлж байгаа ч, үнэлгээ нь хагас жилийн өмнөхөөс дээшилсэн байна. Сүүлийн хагас жилийн хугацаанд эдийн засгийн байдал тааруухан хэвээр байгаа боловч хэрэглэгчдийн хүлээж байсанчлан байдал арай дээр болоход Улаанбаатар хотын хэмжээнд ажилгүйдэл, ядуурал буурсан явдал нөлөөлсөн гэж үзэж байна. Харин хүлээлтийн индекс 111.1 гарснаас харахад Улаанбаатар хотын хэрэглэгчид одоогоос 6 сарын дараа эдийн засгийн нөхцөл байдал дээшлэх төдийгүй сайн болно гэж таамаглаж байна.

Хэрэглэгчдийн итгэлийг тодорхой бүлгүүдээр харья (Хүснэгт 9). Дээд боловсролтой өрхүүд эдийн засгийн байдлыг доогуур боловсролтой өрхүүдээс арай өөдрөгөөр үнэлж байна. Тухайлбал, дээд боловсролтой өрхүүдийн хувьд ХИИ 88.5 байхад доогуур боловсролтой өрхүүдийнх 79.7 байна. Хагас жилийн өмнөхтэй харьцуулахад аль алиных нь итгэл эрс дээшилсэн ба ялангуяа, доогуур боловсролтой өрхүүдийн эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж өмнөхөөс эрс сайжирчээ. Өндөр боловсролтой өрхүүдийн ирээдүйн хүлээлт их өөдрөг (Хүлээлтийн индекс 119.7) байна.

Орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл, гэр болон хашаа байшинд амьдардаг өрхүүдийн

ХИИ орон сууцанд амьдардаг өрхүүдийнхээс арай илүү буюу 7.4 пунктээр өндөр байна. Эхний хагас жилийн судалгаагаар гэр болон хашаа байшинд амьдардаг өрхүүд нь орон сууцанд амьдардаг өрхүүдийг бодвол өнөөгийн байдлыг арай доогуур ирээдүйг арай өөдрөгөөр үнэлж байсан бол хоёрдахь удаагийн ХИИ түүвэр судалгаагаар өнөөгийн болон ирээдүйн байдлын талаар илүү өөдрөг итгэлтэй байна. Үүнд сүүлийн хагас жилд гэр хорооллын ажилгүйдэл, ядуурлын түвшин багагүй буурсан явдал нөлөөлсөн байж болох юм.

#### Хүснэгт 9. Хэрэглэгчийн Итгэлийн Индекс

	Боловсрол <sup>5</sup>				Орон сууцны нөхцөл			
	Дээд		Доо-гуур		Гэр хорооллол		Орон сууц	
	2009-04	2009-10	2009-04	2009-10	2009-04	2009-10	2009-04	2009-10
Хэрэглэгчийн Итгэлийн Индекс	40.6	88.5	34	79.7	36.9	85.1	36.6	77.7
Өнөөгийн байдлын индекс	16.6	41.7	9.9	39.5	10.4	41.2	17.4	38.7
Хүлээлтийн индекс	56.6	119.7	50.1	106.5	54.5	114.3	49.3	103.8

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009


Түүвэр судалгааны дүнгээс үзвэл нийт өрхийн 13.2 хувь нь тэдний санхүүгийн байдал нэг жилийн өмнөхөөс сайжирсан гэж үзэж байгаа нь хагас жилийн өмнөхөөс 2 дахин өндөр үзүүлэлт юм. Мөн нийт өрхийн 35.7 хувь нь муудсан гэж үзсэн нь өмнөх судалгаанаас 44

<sup>5</sup> Өрхийн тэргүүний боловсрол дипломын болон түүнээс дээш бол өрхүүд “дээд” гэсэн ангилалд үгүй бол “доогуур” гэсэн ангилалд орно.





хувиар бага байгааг дараахь зургаас харж болно.



Өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжтой үе гэж 24 хувь нь үзэж байхад 50.4 хувь нь тохиромжгүй гэж үзсэн бөгөөд тохиромжгүй гэж үзэж буй өрхийн тоо хагас жилийн өмнөхөөс 7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 10. Хэрэглэгчийн Итгэлийн Индекс

	Өрхийн санхүүгийн байдал жилийн өмнөхтэй харьцуулахад			Удаан эдэлгээт бараа худалдан авахад тохиромжтой үе эсэх	
	ХИИ-1	ХИИ-2		ХИИ-1	ХИИ-2
Сайн	5.7	13.2	Тохиромжтой	24.8	23.9
Хэвийн	40.4	51.1	Тохиромжгүй	57.1	50.4
Муу	53.9	35.7	Мэдэхгүй	18.1	25.7

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Өрхүүд эдийн засгийн гол гол үнэ ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөнө гэж үзэж буй нь ихээхэн сонирхолтой билээ. Түүвэр судалгааны үр дүнгээс харахад эдийн засгийн гол гол үнэ хагас жил, жилийн хугацаанд өөрчлөгдөнө гэж таамаглаж буй өрхийн тоо 4 сарынхтай харьцуулахад 11 сард харьцангуй цөөрсөн

байна. Нийт өрхийн 46.6 хувь нь ирэх 6 сарын хугацаанд инфляци өснө гэж таамаглаж байгаа бөгөөд тэдний 80 хувь нь инфляцийн түвшин 10 хувиас хэтрэхгүй гэж үзэж байна. Харин нийт өрхийн 7.7 хувь нь ирэх 6 сарын хугацаанд инфляци буурна гэж үзэж байгаа нь 4 сарын судалгаатай харьцуулахад 2 дахин бага байна. Түүнчлэн ирэх 6 сарын хугацаанд америк долларын ханш өснө гэж 30 хувь нь үзэж байгаа бөгөөд үүнээс 72 хувь нь ханш өсч 1450-1600 төгрөг байна гэж үзэж байна. Ханш буурна гэж үзэж байгаа өрхийн тоо хагас жилийн өмнөхөөс 2 дахин бага буюу 14.2 хувь байна.

#### Хүснэгт 11. Хүлээлт

Хариулт	ХИИ-1, 2009-04		ХИИ-2, 2009-10	
	6 сарын хугацаанд	1 жилийн хугацаанд	6 сарын хугацаанд	1 жилийн хугацаанд
<b>Инфляци</b>				
Өснө	49.2	42.6	46.6	45.1
Өөрчлөгдөхгүй	17.7	15.5	22.8	15.6
Буурна	14.3	13.4	7.7	10.1
Мэдэхгүй	18.8	28.5	22.9	29.2
<b>Ам. долларын ханш</b>				
Өснө	30.5	25.9	29.7	28.3
Өөрчлөгдөхгүй	19.0	19.0	22.8	19
Буурна	28.0	20.4	14.2	14
Мэдэхгүй	22.5	34.7	33.3	38.7

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Нийт өрхийн 18.4 хувь нь ирэх нэг жилийн хугацаанд зээлийн хүү өснө гэж үзэж байгаа нь 6 сарын өмнөхөөс эрс бага байна. Түүнчлэн зээлийн хүү буурна гэж таамаглаж буй өрхийн тоо 6 сарын өмнөхөөс өндөр бөгөөд 28.3 хувь байна. Нийт өрхийн тал шахам нь ирэх нэг жилийн хугацаанд орон сууцны үнэ буурна гэж үзэж байхад 18 орчим хувь нь өснө гэж үзэж байна.



## Хүснэгт 12. Хүлээлт, нэг жилийн хугацаанд

Хариулт	Зээлийн хүү		Орон сууцны үнэ	
	2009-04	2009-10	2009-04	2009-10
Өснө	31.7	18.4	21.4	17.7
Өөрчлөгдөхгүй	25.5	25.4	20.2	22.9
Буурна	21.0	28.3	48.9	46.8
Мэдэхгүй	21.8	27.9	9.5	12.6

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

## Өрхийн зарлага

Өмнөх тайландаа бид удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний хэрэглээ нь эдийн засгийн мөчлөгийн дагуу өөрчлөгддөг бөгөөд өөрчлөлтийн хэмжээ нь ДНБ-ий өөрчлөлтөөс хэд дахин их байдаг талаар дурдаж байсан билээ. Үл хөдлөх хөрөнгө худалдан авахаар төлөвлөж байгаа эсэхийг асуухад нийт өрхийн 9.2 хувь эерэг хариулт өгсөн байна. Энэ нь өмнөх ХИИ түүвэр судалгаатай харьцуулахад 1.75 дахин багассан байна. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах 9.2 хувийн 4.0 пункт нь орон сууц, 2.4 пункт нь хашаа байшин худалдан авна гэж хариулжээ.

## Хүснэгт 13. Төлөвлөж буй худалдан авалт

Хариулт	Үл хөдлөх хөрөнгө		Томоохон эд хогшил		Аялал, жуулчлал		Авто-машин	
	2009-04	2009-10	2009-04	2009-10	2009-04	2009-10	2009-04	2009-10
Тийм	16.1	9.2	34.7	32.6	37.7	20.4	16.7	17.7
Үгүй	83.9	90.8	65.3	67.4	62.3	79.6	83.3	82.3

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Улаанбаатар хотын нийт өрхийн бараг гуравны нэг орчим нь томоохон эд хогшил, цахилгаан бараа худалдан авах төлөвлөгөөтэй байгаагаас 17.4 хувь нь хөргөгч, угаалгын машин, компьютер авахаар байна. 2009 оны 4 сарын ХИИ түүвэр судалгаатай харьцуулахад нийт худалдан

авалт төдийлөн буурахгүй харагдаж байгаа боловч дээрх гурван барааны хувьд эрэлт нэлээд буурах хандлагатай байна (24.5 хувь байснаас 7 пунктээр бага байна).

Аялал жуулчлалын хувьд өмнөх хагас жилийн тайлантай харьцуулахад эрс буурсан (2009 оны 4 сард 37.7 хувь байсан бол 2009 оны 11 сард 20.4) нь улирлын чанартай холбоотой байж болох юм. Улаанбаатар хотын өрхүүдийн 11.1 хувь нь хөдөө хамаатан садныдаа, 6 хувь нь дотоодын амралт, сувиллын газар амрахаар төлөвлөж байна. Эдгээр үзүүлэлт нь хагас жилийн өмнөхтэй харьцуулахад хоёр дахин бага байна.

Автомашин худалдан авалтын хандлага 2009 оны 4 сарын байдалтай ойролцоо байхаар байна. Өрхүүдийн 82.7 хувь нь үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг байна. Нийт өрхийн тал орчим нь хашаа байшин, 29.6 хувь нь орон сууц, 29.3 хувь нь газар, 8.2 хувь нь зуслангийн байшин эзэмшдэг ажээ. Энэ нь өмнөх ХИИ түүвэр судалгааны үр дүнтэй нэлээд ойрхон гарчээ. Харин хувьцаа эзэмшдэг өрх 8.2 хувь байгаа нь өмнөх түүврийнхээс (4.8 хувь) өссөн байна.

## Банкны секторт итгэх итгэл

Улаанбаатар хотын өрхүүдийн банкинд мөнгөө байршуулах сонирхол нэмэгдсэн бөгөөд ихэнх нь төгрөгөөр хадгалахыг илүүд үзсэн байна. Харин мөнгөө гэртээ хадгална, эсвэл биет хөрөнгө болгоно гэж хариулсан өрхүүдийн хувь бага зэрэг буурчээ.

## Хүснэгт 14. Мөнгөн хөрөнгийн байршил, хувь

	Банкинд хадгална	Гэртээ хадгална	Биет хөрөнгө болгоно	Бусад
ХИИ-1, 2009-04	57.8	23.6	16.2	2.4
ХИИ-2, 2009-10	65.7	19.0	12.2	3.1

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009



Нийт өрхийн 73.6 хувь нь мөнгөн хөрөнгөө төгрөг хэлбэрээр банкинд, эсвэл гэртээ хадгална, 13.8 хувь нь гадаад валют хэлбэрээр хадгална, 12.6 хувь нь биет хөрөнгө болгоно гэсэн хариулт өгчээ. ХИИ-1 судалгаатай харьцуулахад биет хөрөнгө болгох сонирхол буурсан харагдаж байна. Орон байрны төрлөөр хөрөнгийн байршлын хариултыг сонирхоход орон сууцанд амьдардаг өрхүүд банкинд илүү итгэх хандлагатай (орон сууцны оршин суугчдын 72.3 хувь, гэр хорооллын 62 хувь) байхад гэр хороололд амьдарч байгаа өрхүүдийн хувьд биет хөрөнгө болгоно гэсэн хариулт нь орон сууцныхтай харьцуулахад арай илүү байна.

### Өрхийн орлого, ажил эрхлэлт

Ажил эрхлэлт, орлого, ядуурлын тухай мэдээлэл нь бодлого боловсруулагчид, судлаачдад эдийн засгийн байдлыг үнэлэхэд нэн чухал мэдээлэл юм. Иймд ХИИ түүвэр судалгаа нь энэ талын мэдээллийг цөөн тооны асуултаар авдаг. Эхлээд ажилгүйдлийг авч үзье.

### Ажилгүйдэл

Улаанбаатар хотын ажилгүйдлийн түвшинг 4 болон 11 сарын байдлаар Хүснэгт 16-д харууллаа. Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин 11 сард 6.7 хувь бөгөөд 6 сарын өмнөхөөс 3.3 пунктээр бага байна. Орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл, гэр, хашаа байшинд амьдардаг өрхийн ажилгүйдлийн түвшин 7.7 хувь байгаа нь орон сууцанд амьдардаг өрхийнхөөс 2.9 пунктээр өндөр байна.


### Хүснэгт 16. Ажилгүйдлийн түвшин

	Ажилгүйдлийн түвшин	
	ХИИ-1	ХИИ-2
<b>Улаанбаатар</b>	<b>10.0</b>	<b>6.7</b>
<b>Хүйс</b>		
Эм	11.5	7.5
Эр	8.6	6.0
<b>Байрны нөхцөл</b>		
Орон сууц, хувийн байшин	5.8	4.8
Гэр хороолол	12.7	7.7

Түүнчлэн эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин 7.5 байгаа нь эрэгтэйчүүдээс 1.5 пунктээр өндөр байна. Сүүлийн 6 сарын хугацаанд ажилгүйдлийн түвшин гэр хороололд 5 пунктээр, эмэгтэйчүүдийн хувьд 4 пунктээр буюу эрс буурсан байгааг тэмдэглүүштэй. Улаанбаатар хотын өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдал хагас жилийн өмнөхөөс нэлээд дээр болсон гэж үнэлж байгаа энэ үед эмэгтэйчүүдийн болон гэр хорооллын ажилгүйдэл огцом буурсан байгаагаас үзэхэд эдийн засгийн уналтын үед юуны түрүүнд эдгээр бүлэг ажилгүйдэлд өртдөг байна.

### Орлого

Дараахь зурагт Улаанбаатар хотын өрхийн сарын дундаж орлогын тархалтыг харуулж байна. Улаанбаатар хотод өрхийн сарын дундаж орлого 300.0-400.0 мянган төгрөг байгаа нь хагас жилийн өмнөх үеийнхээс өөрчлөгдөөгүй байна. Орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл орлогын ихээхэн ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, гэр болон хашаа байшинд амьдардаг өрхийн нэг хүнд ногдох дундаж орлого 93.4 мянган төгрөг байгаа нь орон сууцанд амьдардаг өрхийнхөөс 72.3 мянган төгрөгөөр бага байгаа юм.



## Ядуурал

Өрхийн нэг хүнд ногдох орлогын өгөгдлийг ашиглан ядуурлын түвшинг тооцоход, Улаанбаатар хотод ядуурлын түвшин 43.2 байна.<sup>6</sup> Ядуурлын түвшин хагас жилийн өмнөхөөс 14.3 хувиар буурчээ. Түүнчлэн нэн ядуурлыг тооцож үзэхэд 7.7 хувь байна. ХИИ-ээс үзэхэд 11 сард өрхүүд өнөөгийн байдал тааруухан байгаа ч хагас жилийн өмнөхөөс багагүй дээрдсэн гэж үнэлж байгаа бөгөөд мөн үед ядуурлын түвшин ийнхүү буурсан нь 2009 оны эхнээс эхэлсэн эдийн засгийн уналтын улмаас ядуурал эрс өссөн байна гэсэн дүгнэлтийг улам баталгаажуулж байгаа юм.

Дараахь хүснэгтэд ядуурлын түвшинг тодорхой бүлгүүдээр харуулсан байна. Ядуурлын түвшин боловсролын түвшин болон орон сууцны нөхцлөөр ялгаатай хэвээр байна. Тухайлбал, дээд боловсролтой өрхүүдийн 20 хувь нь ядуу байхад, дээдээс доогуур боловсролтой өрхийн талаас илүү нь ядуу байна. Түүнчлэн гэр

<sup>6</sup> Хэрвээ амьжиргааны доод түвшинг 2009 оны шинэчилсэн түвшин болох 101100 төгрөгөөр авбал Улаанбаатар хотын ядуурал 62.2 хувьтай байна. Гэвч сүүлийн хагас жилд үнийн түвшин өсөөгүй (10-р сарын бюллетень, Монголбанк) байгаа нь шинээр тогтоосон амьжиргааны доод түвшний орлогын бодит түвшинг хуучин түвшингээс эрс өндөр болгож, улмаар ХИИ-2 судалгааны үр дүнг хооронд нь харьцуулах боломжгүй болгож байгаа юм. Жишээлбэл, 4 сард ядуу биш байсан өрх, өрхийн бодит орлого хэвээрээ байхад 11 сард ядуу гэж тооцогдож байгаа юм. Иймд харьцуулалт хийх үүднээс ядуурлын түвшинг 94800 төгрөг гэж тооцсон. Түүнчлэн өрхийн орлогын интервалын максимумаар ядуурал 39.0 хувь, минимумаар нь авахад 57.6 хувь байна.

хорооллын ядуурлын түвшин 55.6 хувь байгаа нь орон сууцанд амьдардаг өрхүүдийнхээс 2.5 дахин өндөр байна.

## Хүснэгт 15. Ядуурлын түвшин (хувиар)

	Ядуурлын түвшин	
	ХИИ-1 <sup>2</sup>	ХИИ-2
<b>Улаанбаатар</b>	<b>57.5</b>	<b>43.2</b>
<b>Улаанбаатар хотын ядуу өрхийн тоо</b>	<b>135081</b>	<b>101487</b>
<b>Өрхийн тэргүүний хүйс</b>		
Эм	61.8	55.8
Эр	56.4	41.0
<b>Боловсролын түвшин</b>		
Дээд	34.1	19.9
Дээдээс доогуур	75	56.9
<b>Байрны нөхцөл</b>		
Орон сууц, хувийн байшин	29.8	20.9
Гэр хороолол	74.7	55.6

Сүүлийн хагас жилд Улаанбаатар хотын өрхийн аль ч бүлгийн хувьд ядуурлын түвшин эрс буурсан байна. Ялангуяа, доогуур боловсролтой өрхүүдийн дунд болон гэр хороололд ядуурлын түвшин бараг 20 пунктээр буурчээ. Улаанбаатар хотод эдийн засгийн өнөөгийн байдал хагас жилийн өмнөхөөс нэлээд дээр болсон гэж үнэлж байгаа энэ үед доогуур боловсролтой өрхийн болон гэр хорооллын ядуурал огцом буурсан байгаагаас үзэхэд эдийн засгийн уналтын үед юуны түрүүнд эмзэг бүлгийн амьжиргаа мууддаг гэж дүгнэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, гэр хороололд амьдарч байгаа бага орлоготой өрх, боловсрол доогуур, ажилгүй иргэдийн хувьд эдийн засгийн хямрал нь ядууралд өртөх нэг гол шалтгаан болж байна.

<sup>7</sup> Амьжиргааны доод түвшин 94800 төгрөг



## Дүгнэлт

2009 оны 11 сард хийгдсэн түүвэр судалгаагаар, хэрэглэгчийн итгэлийн индекс 82.8 байгаа нь Улаанбаатар хотод хэрэглэгчийн итгэл тааруухан хэвээр байгаа боловч хагас жилийн өмнөхөөс эрс сайжирсан байна. Ерөнхий индексийн утга ингэж өссөн нь өнөөгийн эдийн засгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмж дээшилсэн болон ирээдүйд итгэх итгэл эрс дээшилж одоогоос 6 сарын дараа эдийн засгийн байдал сайн (хүлээлтийн индекс 111.1) болно гэж хүлээж байгаатай холбоотой байна.

Нийт өрхийн тал нь өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжгүй гэж үзэж байгаа бөгөөд ингэж үзэж буй өрхийн тоо хагас жилийн өмнөхөөс 7 хувиар буурсан байна. Ирэх 6 сарын хугацаанд нийт өрхийн 9.2 хувь нь үл хөдлөх хөрөнгө худалдаж авахаар төлөвлөж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авах болон аялал жуулчлалаар явахаар төлөвлөж буй өрхийн тоо буурсан байгаа бөгөөд үүнд улирлын байдал нөлөөлсөн байж болох талтай.

Эдийн засгийн гол гол үнэ хагас жил, жилийн хугацаанд өөрчлөгдөнө гэж таамаглаж буй өрхийн тоо 4 сарынхтай харьцуулахад 11 сард харьцангуй цөөрсөн байна. Нийт өрхийн тал орчим нь инфляци өснө гэж таамаглаж байна. Нийт өрхийн дунд ирэх нэг жилийн хугацаанд зээлийн хүү өсөхгүй гэсэн таамаглал (53.7%) давамгайлж байна.

Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин 11 сард 6.7 байгаа нь 4 сарынхаас эрс буурсан үзүүлэлт юм. Ажилгүйдлийн түвшинд гарсан өөрчлөлтийг хүйс болон орон сууцны нөхцлөөр

авч үзэхэд бас ч ялгаатай байна. Тухайлбал, гэр хорооллын ажилгүйдлийн түвшний бууралт орон сууцныхаас 5 дахин илүү байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүд, гэр хорооллын оршин суугчид эдийн засгийн уналтын үед ажилгүйдэлд илүүтэй өртдөгийг харуулж байж болзошгүй юм.

Улаанбаатар хотод ядуурлын түвшин хагас жилийн хугацаанд эрс буурч 43.2 болжээ. Гэвч өмнө нь улсын хэмжээнд хийгдсэн бусад судалгаатай харьцуулахад ихээхэн өндөр хэвээр байна. Тухайлбал, 2008 оны “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-гаар Улаанбаатар хотын ядуурлын түвшин 21.9 хувь байгаа юм. ХИИ судалгаа болон “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа” нь 2 зүйл дээр ялгаатай болохыг өмнөх тайланд дурдсан.<sup>8</sup> Гэвч 4 болон 11 сарын ХИИ судалгааны үр дүнг хооронд нь харьцуулж үзэхэд ядуурлын түвшин эдийн засгийн уналттай холбоотой эрс өссөн гэсэн дүгнэлт улам бүр баталгаажиж байна. 11 сард өрхүүдийн өнөөгийн байдал тааруухан байгаа ч хагас жилийн өмнөхөөс нэлээд дээрдсэн гэж үнэлж байгаа бөгөөд мөн үед ядуурлын түвшин хагас жилийн өмнөхөөс мэдэгдэхүйц (14 пунктээр) доогуур байна.

<sup>8</sup> ХИИ түүвэр судалгаа нь өмнөх судалгаанаас дараахь ялгаатай. Нэгд, ХИИ-ийн түүвэр судалгаа явуулах үеийн эдийн засгийн орчин, “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа” хийгдсэн үеийн эдийн засгийн орчноос эрс ялгаатай юм. ХИИ-ийн түүвэр судалгаанууд нь эдийн засгийн үйл ажиллагаа ихээхэн суларсан үед хийгдсэн бол “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа” нь 2008 он буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрчимтэй буюу хэт халалттай байх үед хийгдсэн. Хоёрт, ХИИ-ийн түүвэр судалгаа нь өрхийн орлогын мэдээлэлд үндэслэсэн. Ийм тохиолдолд, өрх орлогоо санаатай болон санамсаргүйгээр дутуу мэдээлэх эрсдэл байдаг. Тухайлбал, орлогоо зориуд багасгаж хэлэх эсвэл мөнгөн бус хэлбэрээр орж ирдэг орлогоо оруулж тооцоогүйгээс дутуу мэдээлэх явдал тохиолддог. Гэвч түүвэр судалгааны мэдээллийг ашиглан шалгахад зориуд багасгасан тохиолдол маш ховор байгаа юм.



ХИИ судалгаанаас харагдаж буй нэг сонирхолтой үр дүн нь өрхийн амьжиргаа болон ядуурах эмзэг байдал хүйсээр, орон сууцны нөхцөл, боловсролоор эрс ялгаатай байгаа явдал юм. Доогуур боловсролтой, эсвэл гэр хороололд оршин суудаг хүмүүс болон эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин өндөр, амьжиргааны түвшин доогуур байх хандлага ажиглагдаж байна. Цаашилбал, эдгээр бүлгийн ядуурах эмзэг байдал өндөр буюу эдийн засгийн уналтын үед бүлгийн амьжиргаа, ажил эрхлэлт эн тэргүүнд эрсдэлд өртдөг байна.

Энэ бүгдээс дүгнэхэд, сүүлийн 6 сарын хугацаанд эдийн засагт хэрэгжүүлсэн бодлого, тухайлбал, макро эдийн засгийн мөнгө, сангийн хатуу бодлого суларсан нь Улаанбаатар хотын өрхүүдийн ажил эрхлэлт, амьжиргаанд нааштай нөлөөлсөн байна. Гэхдээ хэрэглэгчдийн үзэж байгаагаар эдийн засаг уналтын байдалтай хэвээр байгаа бөгөөд харин хагас жилийн

дараагаас байдал хэвийн болохоор хүлээгдэж байна.

Хоёр удаагийн ХИИ түүвэр судалгааны үр дүнгээс харахад энэхүү судалгаа нь эдийн засгийн ерөнхий хандлага, одоогийн хэрэгжүүлж буй бодлогын нөлөөг үнэлэх болон цаашид хэрэгжүүлэх бодлого боловсруулалтад шаардлагатай тодорхой мэдээллийг өгч буйгаараа ихээхэн ач холбогдолтой юм. Тухайлбал, энэхүү судалгаагаар ажилгүйдэл буурсан үр дүн гарсан нь Дэлхийн Банкнаас гаргадаг Монголын эдийн засгийн тоймд (№9) дурдсан албан ёсны болон албан бус ажилгүйдлийн түвшин буурсан мэдээтэй нийцэж байгаа бөгөөд наймдугаар сараас ажиглагдаж эхэлсэн ажилгүйдэл буурах хандлага давхар батлагдаж байна.

ХИИ тооцсон хоёр удаагийн судалгаа нь яг нэг аргачлал, ижил асуулгаар давтан хийгдсэн бөгөөд судалгааны үр дүнг өөр хооронд нь шууд харьцуулах боломжтойгоороо давуу талтай юм.

## Бодлогын зөвлөмж

- Хэрэглэгчийн эдийн засагт итгэх итгэл муу байгаа энэ үед тэдний итгэлийг сайжруулахын тулд нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын хандлага болон эдийн засгийг дэмжихэд чиглэсэн төрийн бодлогын талаар олон нийтэд тодорхой, шуурхай мэдээлэх шаардлагатай.
- Түүнчлэн ойрын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт эрэлт бага хэвээр байх хандлагатай энэ үед төр өөрийн зарлагаараа дамжуулан нийт эрэлтийг урамшуулах боломжтой боловч хэрэглэгчид хагас жилийн хугацаанд эдийн засгийн

байдал хэвийн болно гэж таамаглаж буйгаас үзэхэд төрийн зарлагыг цаашдаа хэт өсгөхөөс болгоомжлох нь зүйтэй .

- Хэрэглэгчийн итгэлийн индекс судалгаагаар гарсан үзүүлэлт, үр дүнг нийгмийн халамжийн тогтолцоог боловсронгуй болгох, төрийн зарлагын үр ашгийг дээшлүүлэхэд ашиглах боломжтой.
- Гэр хороололд амьдарч байгаа өрхүүд орон сууцанд байгаа өрхүүдээс эрс доогуур амьжиргаатай (ажилгүйдэл өндөр, ядуурал их, амьдрах орчин нөхцөл муу, боловсрол доогуур г.м.) байгаад анхаарч

түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- ХИИ түүвэр судалгааг цаашид тодорхой хугацааны давтамжтайгаар үргэлжлүүлэн хийх нь хэрэглэгчдийн хүлээлтэд гарч байгаа өөрчлөлтийн хандлагыг тод харуулах улмаар түүнийг бодлогод тусгах боломжийг олгоно.

- ХИИ-ийг тооцох хоёрдахь түүвэр судалгааны дүнгээс харахад ядуурлын шугам бага зэрэг өөрчлөгдөхөд л ядуу өрхийн тоонд эрс өөрчлөлт орж байгаа нь орлогын хувьд ядуурах магадлал өндөртэй эмзэг бүлгийн талаар тусгайлан бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ядуу эмзэг бүлгийнхэнд чиглэсэн бодлогуудыг зангидаж зохицуулах шаардлагатайг харуулж байна.

## Ашигласан материал

1. Conference Board, 2000 "Consumer Confidence Survey"
2. Richard Gabay, 2004 "Survey results: Uncertainty rises in June", The Conference Board of Canada
3. International Center for Policy Studies, "Consumer Moods in Ukraine, 2009"
4. Sydney C.Ludvingston "Consumer Confidence and consumer spending", The Journal of Economic Perspectives, Vol.18, No 2, pp 29-50
5. Jeff Dominitz, Charles F.Manski "How should we measure consumer confidence?" The Journal of Economic Perspectives, Vol.18, No 2, pp 51-66
6. ҮСГ, 2000 он "Хүн ам орон сууцны тооллого"
7. ҮСГ, 2004 он "Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан"
8. Сант марал, 2009 "Банкны салбарын судалгаа"
9. ҮСГ, 2009 он "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүнгийн үндсэн хүснэгтүүд", урьдчилсан тайлан
10. Монгол банк, Мөнгөний бодлогын газар, 2005 "Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх түүвэр судалгаа-2005", Монгол банк
11. Friedman, Milton, 1957 "A Theory of the consumption function" Princeton University Press
12. Mankiw, N.Gregory, 1982 "Hall's consumption hypothesis and durable goods", Journal of Monetary Economics 10, 417-425
13. Romer, Christina D. 1986 "Spurious Volatility in Historical Unemployment Data", Journal of Political Economy 94, pp1-37
14. <http://www.conference-board.org/economics/ConsumerConfidence.cfm>
15. [www.investopedia.com/terms/m/mcsi.asp](http://www.investopedia.com/terms/m/mcsi.asp)
16. <http://www.washingtonpost.com/wp-srv/business/articles/consumerindexdata.htm>
17. <http://www.masterintelligence.com/ViewRegion-Report.jsp?hidReportTypeId=2&hidRegionId=1&hidUserId=null>
18. [http://www.xinhuafinance.com/en/charts/indicator/ccci/ccci0809\\_en.jpg](http://www.xinhuafinance.com/en/charts/indicator/ccci/ccci0809_en.jpg)



## Хавсралт

### Хүснэгт Х1. Үл хөдлөх болон санхүүгийн хөрөнгө

	Үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг эсэх		Үнэт цаас, хувьцаа эзэмшдэг эсэх	
	ХИИ-1	ХИИ-2	ХИИ-1	ХИИ-2
	Тийм	80.8	82.7	4.8
Үгүй	19.2	17.3	95.2	91.8

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

### Хүснэгт Х2. Үл хөдлөх хөрөнгийн төрөл (нийт өрхөд эзлэх хувь)

	Орон сууц	Хашаа байшин	Газар	Гэр	Зуслангийн байр
ХИИ-1	27.6	42.5	27	14.5	7.7
ХИИ-2	29.6	47.2	29.3	13.0	8.2

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

### Хүснэгт Х3. Ажиллах хүч

Хүйс	Хөдөлмөрийн насны хүмүүст эзлэх хувь	
	ХИИ-1	ХИИ-2
Эм	53.2	52.9
Эр	46.8	47.1
<b>Сүүлийн 7 хоног ажил эрхэлсэн эсэх</b>		
Тийм	47.4	52.5
Үгүй	52.6	47.5

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

### Хүснэгт Х4. Ажил эрхлэлт салбараар

Ажилладаг салбар	Ажил эрхэлж буй хүмүүст эзлэх хувь	
	ХИИ-1	ХИИ-2
ХЭАА, нөхөрлөл, хоршоолол	4.9	4.2
Хувьцаат компани	14.5	20.6
ХХК	20.2	14.3
Улсын үйлдвэрийн газар	2.5	2.9
Төрийн, төсөвт байгууллага	26.3	21.6
Төрийн бус байгууллага	5.0	5.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	26.6	30.7

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

### Хүснэгт Х5. Ажил эрхлэлтийн байдал

	Ажил эрхэлж буй хүмүүст эзлэх хувь	
	ХИИ-1	ХИИ-2
Гэрээгээр ажиллагч	60.5	55.4
Ажил олгогч	5.6	4.6
Хувиараа ажиллагч	25.5	31.9
Хоршооллын гишүүн	1.5	0.9
Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч	2.0	1.5
Бусад	4.9	5.8

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

### Хүснэгт Х6. Ажил эрхлээгүй байгаа шалтгаан

	Ажил эрхлээгүй хүмүүст эзлэх хувь	
	ХИИ-1	ХИИ-2
Сургуульд сурдаг	40.4	44
Тэтгэвэр, нөхөн олговорт	16.8	18.7
Өвчтэй, тахир дутуугийн группт	6.3	4.3
Гэрийн ажилтай	11.3	9.7
Тохирох ажил олдохгүй байгаа	8.9	9.5
Ажил хайж байгаа	10	8
Бусад	6.3	5.8

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009